



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐24 оны 1᠐ сарын 14 өдөр

Дугаар А/342.

Улаанбаатар хот

Нийслэлийн Өргөө амаржих газрын
данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 9 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Памперс Монголия ХХК болон иргэн Байгальмаа нар хандивласан нийт 11,909,700.00 (арван нэгэн сая есөн зуун есөн мянга долоон зуу) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Нийслэлийн Өргөө амаржих газар (Д.Наранцацралт)-т зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Өргөө амаржих газар (Д.Наранцацралт)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2024 оны 40 дугаар сарын 14-ны өдрийн
Д.442 дугаар тушаалын хавсралт

Байгууллагын нэр: Нийслэлийн өргөө амаржих газар

Д/д	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжээн жлгөн	Тоо	Бүртгэлийн анхны үнэ /төгрөгөөр/		Хөрөнгө оруулалтын шийдвэр болон хандивлагчийн нэр	Хөрөнгийн эх - үүсвэр
							нэгжийн үнэ	нийт дүн		
1	Хүлээлгийн сандал	Хятад	2024	сайн	ш	2	540,000	1,080,000	Rampers mongolia	Хандив
2	Бөөрөнхий цагаан ширээ	Хятад	2024	сайн	ш	1	330,000	330,000	Rampers mongolia	Хандив
3	Амралтын сандал	Хятад	2024	сайн	ш	2	249,900	499,800	Rampers mongolia	Хандив
Тавилга, эд хогшлын дүн							1,909,800			
1	Зурагт	Samsung 55 инч	2024	сайн	ш	1	2,999,900	2,999,900	Rampers mongolia	Хандив
2	Ургийн монитор	БНСУ FC-1400	2024	сайн	ш	1	7,000,000	7,000,000	Байгальмаа	Хандив
Машин, тоног төхөөрөмжийн дүн							9,999,900			
НИЙТ БҮРТГЭХ ДҮН							11,909,700			